



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 03/02

Арвайхээр

Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “а”, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг нэгдүгээр, түүний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. “Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгагдсан зорилт, арга хэмжээг тухайн жилийн “Хөгжлийн жилийн төлөвлөгөө”-нд тусган хэрэгжүүлж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж байхыг аймгийн Засаг дарга /А.Ишдорж/-д даалгасугай.

ДАРГА



О. ПҮРЭВДОРЖ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн
03/02 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ

Зорилго: Нийгмийн суурь үйлчилгээг иргэдэд тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар нийгмийн дундаж давхаргын хамрах хүрээг өргөжүүлэн, гэр бүлд ээлтэй, жендерийн мэдрэмжтэй цогц бодлого хэрэгжүүлнэ.

1.1. Үндэсний бахархал, өв соёл

Зорилт 1. Эх хэл, соёл, ёс заншлаа дээдэлсэн эх оронч үзэлтэй эв нэгдлийг эрхэмлэсэн иргэнийг төлөвшүүлэн хөгжүүлж, түүх, соёлын өвөө хамгаалан, үндэсний бахархлаа түгээн дэлгэрүүлж, соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.1.1.1. Уламжлалт монгол ахуй, өв соёлоо сэргээж, монгол бичгийн бүх нийтийн хэрэглээг нэмэгдүүлэн, иргэдэд угийн бичиг хөтлүүлэх замаар монгол хүний удмын санг хамгаалах арга хэмжээ авч, түүх, өв соёлоо хадгалан хамгаалж, үндэсний бахархлаа түгээн дэлгэрүүлэх ажлуудыг зохион байгуулж, ёс заншлаа дээдэлсэн эх оронч иргэнийг төлөвшүүлнэ.

1.1.1.2. Иргэд, олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх замаар соёлын үл хөдлөх өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсооно.

1.1.1.3. Биет бус өвийг өвлөн уламжлах шавь сургалтыг хөгжүүлэх ажлыг бодлогоор дэмжин, төв халхын болон нутгийн онцлогтой өвийг хамгаалж, төрөл бүрийн хэлбэрээр хадгалж архивлах арга хэмжээг зохион байгуулна.

1.1.1.4. Орон нутгийн соёл урлагийн байгууллагын орчин нөхцөлийг сайжруулан, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хүний нөөцийг бүрдүүлэн, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

1.1.1.5. Аймгийн музей, сумдын орон нутаг судлах танхимын үзүүлэлэг, дэглэлтийг сайжруулан, үйл ажиллагааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлж, музейн үзмэрийн санд жилд 50-иас доошгүй сая төгрөгөөр баяжилт хийнэ.

1.1.1.6. Мэргэжлийн урлагийн байгууллагын уран бүтээл туурвих үйл ажиллагааг дэмжиж, иргэдийн урлагийн мэдрэмж, хүртэх орчинг бүрдүүлэн, соёл, урлагийн үйлчилгээг хөдөөгийн иргэдэд зайны болон нүүдлийн хэлбэрээр хүргэнэ.

1.1.1.7. Соёлын өв, урлаг, уран бүтээл, урлал, музейн үйл ажиллагааг аялал жуулчлалтай холбон хөгжүүлнэ.

1.1.1.8. Аймгийн Хөгжимт драмын театрын мэргэжлийн уран бүтээлчдийг дэмжих замаар чанартай уран бүтээл туурвих нөхцөлийг бүрдүүлэн, дотоод, гадаадын сургалтад хамруулж, тэдний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, “Сонгодог урлаг-3” арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.1.1.9. Номын сангийн үйлчилгээний оновчтой хэлбэрийг бий болгож, орон тоо, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэн, номын сангуудыг цахим болгон хөгжүүлж, аймгийн Төв номын сангийн фондод жилд 5-аас доошгүй сая төгрөгөөр баяжилт хийнэ.

1.2.Эрүүл мэнд

Зорилт 1. Эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулснаар хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.

1.2.1.1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэргүүлэх чиглэлээ болгон “Нийгмийн эрүүл мэндийн төв”, “Бүсийн оношилгоо, эмчилгээний төв”-ийн дэргэд урьдчилан сэргийлэх “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийг амбулаторийн зохион байгуулалттайгаар байгуулж, хорт хавдрын эрт илрүүлэх үзлэг оношилгоо, шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлэн, хөнгөвчлөх эмчилгээ, сувилгааг чанаржуулна.

1.2.1.2. Хүн амын эрүүл идэвхтэй амьдралын дэмжлэгт орчинг байгууллага, аж ахуйн нэгж, сум, баг, өрх бүрт бүрдүүлж, халдварт ба халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх, эрүүлжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд иргэд, төрийн ба төрийн бус байгууллага, салбар хоорондын уялдааг ханган ажиллаж, сэргийлж болох нас баралтыг бууруулна.

1.2.1.3. Орчин үеийн оношилгоо, эмчилгээний дэвшилтэт технологийг нутагшуулж, эмчилгээ, үйлчилгээ, эм олголтыг цахимжуулах замаар иргэд аймаг, сумандаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай авах нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2.1.4. Яаралтай болон гэмтлийн тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагын нэгжийн тоог нэмэгдүүлж, иргэд ойр газраас, богино хугацаанд яаралтай тусламж авах нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2.1.5. Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг олгох, үйлчлүүлэгч эмчээ сонгон эмчлүүлэх боломжийг бүрдүүлэн, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Хархорин сумын Нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулан, бие даан хөгжих нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2.1.6. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй, тасралтгүй байдлыг хангаж, сумдын эмийн сангийн тоог нэмэгдүүлэн өрсөлдөөн бий болгох замаар эмийн үнийг тогтвортой байлган, клиникийн эм зүйн тусламжийг хөгжүүлж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.

1.2.1.7. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, сургалт хөгжил, нийгмийн хамгааллыг дэмжих замаар үндсэн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч, сувилагчийн тоог нэмэгдүүлнэ.

1.2.1.8. Сумдын болон Өрхийн эрүүл мэндийн төвд дэд бүтцийн дэмжлэг үзүүлэн, өдрийн, гэрийн, нөхөн сэргээх тусламж үйлчилгээг өргөжүүлж, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авах боломжийг бүрдүүлэн, Өрхийн эрүүл мэндийн төвийн статусыг Засгийн газрын шийдвэрт нийцүүлэн зохион байгуулна.

1.2.1.9. Сумдын Эрүүл мэндийн төв болон Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сумдын эрүүл мэндийн төвүүд болон уламжлалт, нөхөн сэргээх, сувилахуй, шүдний гажиг заслын хөнгөвчлөх кабинетуудын үйл ажиллагааг дэмжин шаардлагатай хүний нөөц, тоног төхөөрөмжөөр хангаж, Арвайхээр суманд уламжлалтын эмнэлгүүдийг байгуулна.

1.2.1.10. Аймаг, сумдын эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, дэд бүтцийг сайжруулна.

1.3.Биеийн тамир

Зорилт 1. Нийтийн биеийн тамирыг бүх нийтийн хөдөлгөөн болгож хөгжүүлэн, мэргэжлийн спортыг дэмжиж, биеийн тамир, спортод ээлтэй орчныг бүрдүүлнэ.

1.3.1.1. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал бий болгоход төрийн болон хувийн хэвшил, мэргэжлийн холбоодын оролцоог нэмэгдүүлж, дэмжинэ.

1.3.1.2. Биеийн тамир, спортын салбарыг хөгжүүлэхэд шаардагдах хүний нөөцийг бүрдүүлж, чадавхижуулан спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.3.1.3. Үндэсний болон багийн спортыг хөгжүүлж, олон улсын жишигт нийцсэн талбай бүхий зуны спортын цэнгэлдэх хүрээлэн, өвлийн спортын бэлтгэлийн төвийг байгуулна.

1.4.Боловсрол

Зорилт 1. Хүн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, бүрэн хамруулна.

1.4.1.1. Суралцагчдад монголын түүх, эх хэл, өв соёл, уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хос бичигтэн болох болон шударга ёсны үзэл хандлагыг төлөвшүүлнэ.

1.4.1.2. Яслид 1-2 настай, хүүхэд харах үйлчилгээнд 2-3 настай, 3-5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд /5 настныг заавал/ хамруулж, хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана.

1.4.1.3. Судалгаа, шинжилгээний ажлын үр дүнгээр шинэ бүтээл, оновчтой санал /инноваци/ нэвтрүүлсэн багш, удирдах албан хаагч нарт урамшуулал олгоно.

1.4.1.4. Соёл, урлагийн хүний нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор төвийн бүсийн “Хөгжим бүжгийн коллеж”-ийг Арвайхээр суманд байгуулна.

1.4.1.5. Сургалтын байгууллагуудын сурч, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

1.4.1.6. Хүн амын өсөлт, газар зүйн мэдээллийн системд суурилж сургууль, цэцэрлэг, дотуур байрын хүчин чадал, ашиглалт, бүтэц, хэв шинж, байршлыг оновчтой тогтоож, боловсролын үйлчилгээний хүртээмж, тэгш байдлыг хангана.

1.4.1.7. Ерөнхий боловсролын сургалтын чанарыг дэлхийн жишигт нийцүүлэх зорилтын хүрээнд сургуулиудыг олон улсын PISA үнэлгээнд хамруулна.

1.4.1.8. Ерөнхий боловсролын сургуулиудад "Үдийн хоол" үйлчилгээг бүрэн нэвтрүүлнэ.

1.4.1.9. Багш, иргэд, суралцагч нарын оролцоотойгоор сургалтын цахим платформыг хөгжүүлэн, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран суралцах боломжийг бүрдүүлнэ.

1.4.1.10. "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлж, мэргэжлийн стандартыг нэвтрүүлэн, үнэлэмжийг хөдөлмөрийн бүтээмж, гүйцэтгэлд суурилан хэрэгжүүлнэ.

1.4.1.11. Боловсролын удирдлагын мэдээллийн системийг бодлого, төлөвлөлт, статистик мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээнд ашиглан, боловсролын үйлчилгээг цахимжуулна.

1.5. Хүүхэд, залуучууд, гэр бүлийн хөгжил

Зорилт 1. Гэр бүлд ээлтэй орчин нөхцөлийг бүрдүүлж, өрхийн гишүүн бүрийн оролцоо, хөгжлийг дэмжсэн, эрүүл эерэг хандлагыг төлөвшүүлсэн, бүтээлч, хөдөлмөрч гэр бүлийг бэхжүүлнэ.

1.5.1.1. Айл өрхүүдийг гадна дэд бүтэцэд холбох, гадна орчны тохижилтыг сайжруулах ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэн, цахим орчинд гэр бүлийн зүй зохистой харилцааны талаархи мэдээллийг түгээх замаар гэр бүлд ээлтэй бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

1.5.1.2. Хүүхдийг хөдөлмөрийн мөлжлөгөөс сэргийлэх ажлыг салбар дундын зохицуулалтаар хангаж, гэр бүлийн хүчирхийлэл, сэтгэл зүйн дарамт, гэр бүл салалтын эсрэг хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, стрессийн сэтгэл зүйч ажиллуулна.

1.5.1.3. Залуучуудын хамтарч хөгжих боломжийг бий болгож, тэднээс нийгмийн оролцооны талаар гаргасан санал санаачилгыг дэмжин ажиллана.

1.5.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэх боломжоор ханган, нийгмээс тэдэнд ялгамжгүй хандах үзлийг төлөвшүүлнэ.

1.5.1.5. Хүүхдийн болон гэр бүлийн зусланг байгуулж, түүгээр дамжуулан гэр бүлийн хөгжлийг дэмжинэ.

1.6.Шинжлэх ухаан, инноваци

Зорилт 1. Орон нутгийн онцлогт тулгуурлан их дээд сургуулийг шинээр байгуулна.

1.6.1.1. Хөдөө аж ахуй, аялал жуулчлалын чиглэлийн магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрүүдийг судлан, орон нутгийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн их, дээд сургууль байгуулах шаардлагатай төсөв хөрөнгийг үе шаттайгаар шийдвэрлэнэ.

1.6.1.2. Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтрах түшиц сургалт судалгааны газрыг бий болгох замаар, инновацийн нэгжийг үүсгэн байгуулж ажил олгогч, мэргэжлийн холбоод, эрдэмтэн багш, судлаачдын түншлэлийг бэхжүүлнэ.

1.7.Хөдөлмөр, нийгмийн хамгаалал

Зорилт 1. Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангаж, халамжаас хөдөлмөр эрхлэлтийн бодлого руу шилжүүлэх замаар, амьдралын баталгааг ханган, иргэн бүрийг ажилтай, орлоготой болгохыг зорьж, нийгмийн дундаж давхаргыг нэмэгдүүлнэ.

1.7.1.1. Олон улсын болон төрийн бус байгууллагуудтай хамтарч хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.

1.7.1.2. Хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн гурван талт хамтын хэлэлцээрийн хэрэгжилтийг сайжруулж, салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлнэ.

1.7.1.3. Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг шинэчилж, хөдөлмөрийн нөхцөлийг үе шаттай сайжруулах ажлыг нийгмийн түншлэлийн оролцоотойгоор шийдвэрлэнэ.

1.7.1.4. Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх талаар ажил олгогчийн үүрэг хариуцлагыг дээшлүүлж, ажилтан аюул эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах чадвар дадлыг төлөвшүүлнэ.

1.7.1.5. Залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн бизнесийн шинэ санааг хөгжүүлэх, дэмжих бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.7.1.6. Техник мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг бүс нутгийн тэргүүлэх сургууль болгон хөгжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд тулгуурлан мэргэжилтэй ажилтан бэлтгэн, төгсөгчдийг ажлын байраар хангана.

Зорилт 2. Нийгмийн даатгалын үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлж, зорилтот бүлгийг оновчтой сонгож нийгмийн хамгааллын үйлчилгээг үзүүлнэ.

1.7.2.1. Нийгмийн даатгалын мэдээллийг бүрэн цахимжуулж, иргэд, даатгуулагчдад үзүүлэх, үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй хүргэнэ.

1.7.2.2. Хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчдыг нийгмийн даатгалд хамруулж, тэдний нийгмийн баталгааг хангана.

1.7.2.3. Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын хурлыг цахимаар зохион байгуулж, шаардлагатай тохиолдолд нүүдэллэн ажиллах зардлыг зохих шатны төсөвт тусган, зорилтот бүлгийг оновчтой сонгож буй байдалд хяналт тавьж ажиллана.

1.7.2.4. Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээнд тулгуурлан нийгмийн халамж авах зорилтот бүлгийг оновчтой сонгож, тавих хяналтыг нэмэгдүүлэн, нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулж, ил тод байдлыг ханган ажиллана.

1.7.2.5. Халамжийн байгууллагын нийгмийн ажилтны тоог нэмэгдүүлэх зорилт тавьж, тэднээр зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг гүйцэтгүүлнэ.

1.7.2.6. Олон улсын болон төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтарч “Нэг өрх-нэг ажлын байр” хөтөлбөр шинэчлэн боловсруулж, халамжаас хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх замаар ядуурлын хамрах хүрээг бууруулна.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ

Зорилго: Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарыг эрчимтэй хөгжүүлж, эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, олон тулгуурт эдийн засаг бүхий өрсөлдөх чадвартай аймаг болно.

2.1.Эдийн засаг

Зорилт 1. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн үндсэн дээр худалдаа, үйлчилгээ, тээвэр логистикийн салбарыг хөгжүүлнэ.

2.1.1.1. Арвайхээр хотод хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, түүхий эд, барилгын материалын агуулахын болон бөөний худалдааны төв байгуулахыг дэмжинэ.

2.1.1.2. Сумдад худалдаа, үйлчилгээ, хөдөө аж ахуйн чиглэлийн томоохон аж ахуйн нэгж байгуулах санаачилгыг дэмжинэ.

2.1.1.3. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр хэрэгжих эдийн засгийн үр өгөөж бүхий зарим томоохон төслүүдийг концессын гэрээний хэлбэрээр хэрэгжүүлнэ.

2.1.1.4. Улс, бүсийн чанартай, босоо болон хэвтээ тэнхлэгийн тээвэр, аялал жуулчлалын авто замын төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэлийг төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж хэрэгжүүлнэ.

2.1.1.5. Арвайхээр хотыг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, аялал жуулчлал, барилгын материалын худалдаагаар баруун болон хангайн бүсийг хангасан худалдаа, үйлчилгээ, тээвэр логистикийн төв, Хархорин хотыг Монгол орны аялал

жуулчлал, түүх соёлын төв болгон хөгжүүлж, бусад сумдыг дээрх 2 хотыг түшиглэн хөгжүүлнэ.

2.1.1.6. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө эдийн засаг, нийгмийн үр ашгийг ач холбогдлоор нь эрэмбэлж хэрэгжүүлнэ.

2.2 Санхүү, төсөв

Зорилт 1. Төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, төсөв, санхүүгийн хариуцлагатай тогтолцоог бүрдүүлнэ.

2.2.1.1. Төсөв, санхүүгийн нэгдсэн цахим систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай үр дүнтэй болгож, гадаадын зээл тусламж, төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулна.

2.2.1.2. Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулна.

2.2.1.3. Улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг эдийн засаг, нийгмийн үр ашигтай төсөл арга хэмжээнд чиглүүлнэ.

2.2.1.4. Төрийн худалдан авах ажиллагаанд дотоодын давуу эрх тооцох замаар худалдан авалтыг дэмжиж, тендер шалгаруулалтын үйл ажиллагаанд дэвшилтэт технологи ашиглана.

Зорилт 2. Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгож, татварын бааз суурийг нэмэгдүүлнэ.

2.2.3.1. Татварын бүх төрлийн үйлчилгээг цахимжуулж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүртээмжтэй ил тод болгоно.

2.2.3.2. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд, салбар компаниудыг орон нутгийн татварын албанд бүртгэлтэй болгон, татварын баазыг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэн төсвийн орлогыг нэмэгдүүлнэ.

2.2.3.3. Малын тоо толгойн албан татварыг тогтоосон зохих хувь хэмжээгээр хурааж татварын орлогыг нэмэгдүүлнэ.

Зорилт 3. Уян хатан, цахим технологид суурилсан олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлнэ.

2.2.4.1. Иргэд олон нийтийн хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэгийг дээшлүүлж, үнэт цаасны зах зээлийн арилжаанд оролцогчдын тоог нэмэгдүүлнэ.

2.2.4.2. Өрхийн болон хувь хүний санхүүгийн боловсрол олгох, мөнгөн тэмдэгтийн хэрэглээг зохистой зөв хэрэглэх, аюулгүй, цахим санхүүгийн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг бичил санхүүгийн болон мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

Зорилт 4. Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоот компани, аж ахуйн нэгжийн засаглалыг сайжруулж, хариуцлагын тогтолцоог бий болгон аймгийн эдийн засагт оруулах үр өгөөжийг нэмэгдүүлэн орон нутгийн өмчийн менежментийг сайжруулна.

2.2.5.1. Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компани, аж ахуйн нэгжүүдийн дүрэм, журмыг хуульд нийцүүлж, удирдлагын багийг компанийн засаглалын сургалтад хамруулж чадавхижуулна.

2.2.5.2. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн мэргэжлийн боловсон хүчний нөөцийг бүрдүүлж, сургаж мэргэшүүлнэ.

2.2.5.3. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийг ашигтай ажиллуулах бодлого баримталж, алдагдалтай ажилласан компанийн удирдлагад хариуцлага тооцно.

2.2.5.4. Орон нутгийн өмчийн бүртгэлийн нэгдсэн цахим санг бий болгож, удирдлагын шийдвэр гаргах түвшинд ашиглана.

2.2.5.5. Орон нутгийн өмчид бүртгэлтэй ашиглалтгүй барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг эдийн засгийн эргэлтэд оруулж, өмчийг бүртгэлээс хасах, худалдах, шилжүүлэх, үйл ажиллагааг ил тод нээлттэй болгоно.

2.2.5.6. Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, тэдгээрийн бүртгэл мэдээлэл, үнэлгээ, тайланг ил тод нээлттэй болгон, өмч эзэмшигчдийн хариуцлагыг дээшлүүлнэ.

2.3.Уул уурхай, хүнд үйлдвэр

Зорилт 1. Орон нутгийн хөгжил, эдийн засгийн өсөлтийг хангах уул уурхайн орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулж хариуцлагатай уул уурхайг дэмжинэ.

2.3.1.1. Баянтээгийн уурхайн менежментийг сайжруулж, ашиглалтын нөөцийг нэмэгдүүлэн, 20 МВт-ийн цахилгаан станц барьж, сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийг өргөтгөж, өөрийн болон зэргэлдээх аймгуудыг сайжруулсан шахмал түлшний хэрэгцээг хангаж, агаарын бохирдлыг бууруулна.

2.3.1.2. Улсын болон хувийн хэвшлийн хөрөнгөөр уул уурхайн орд газруудад хийгдэх геологи, хайгуул судалгааны ажлыг дэмжин, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулна.

2.3.1.3. Уул уурхайн олборлох болон байгалийн нөөц ашиглах салбарт төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын түншлэлийг хөгжүүлж, нийгмийн хариуцлагын гэрээг хэрэгжүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангана.

2.4.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр

Зорилт 1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг тооноос чанарт шилжүүлж, сүргийн зохистой бүтцийг хадгалах замаар түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг бүрдүүлнэ.

2.4.1.1. Аймгийн хэмжээнд мал сүргийн үржил селекцийн ажлыг биотехнологийн ололтод тулгуурлан явуулж, малын чанарыг сайжруулж бүс нутгийн онцлогт тохирсон хэвшил, омог, үүлдэр бий болгоно.

2.4.1.2. Малчин өрхийг малын эрсдэлийн даатгалд хамруулж, цөм сүргийн мал болон хээлтүүлэгчийг ялган тэмдэглэж бүртгэлжүүлнэ.

2.4.1.3. Бэлчээрийг усжуулах, хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой байдлыг хангах, бэлчээрийн доройтол, цөлжилтийг бууруулж, сум дундын отрын бүс нутгийн бэлчээрийг нэмэгдүүлэн, аймаг, сумдын өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлнэ.

2.4.1.4. Эрчимжсэн мал аж ахуй болон туслах аж ахуйг хөгжүүлнэ.

2.4.1.5. Вакцин хэрэглээний аюулгүй байдлыг ханган үйлдвэрлэлийн аргаар бэлтгэсэн мах, махан бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, түүний хяналт мэдээллийн тогтолцоог бий болгох нэгдсэн системийн мэдээллийг цахимжуулна.

2.4.1.6. Халдварт, халдваргүй, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлж, эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай малын эм, биобэлдмэлийн зохистой хэрэглээг төлөвшүүлж, эм биобэлдмэлийн үнийн тогтвортой байдлыг хангана.

2.4.1.7. Мал, амьтны өвчний гаралт, тархалтыг бууруулж, халдварт өвчнөөр орон нутгийн тайван байдлыг баталгаажуулна.

Зорилт 2. Стратегийн хүнсний зориулалттай болон бусад нэр төрлийн ашигт таримлын тариалалт болон хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж, дотоодын хэрэгцээг хангах, шинэ нэр төрлийн таримлын бүтээгдэхүүн бий болгож импортыг бууруулна.

2.4.2.1. Эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, баталгаажсан сортын үр, бордоо, техникийн дэмжлэгт тариаланчдыг хамруулснаар хэрэгцээт үр тарианы 60, төмсний 100, хүнсний ногооны 50 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, жимс, жимсгэнэ, малын тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлнэ.

2.4.2.2. Хураан авсан төмс, хүнсний ногоог нөөцлөх, хадгалах нөхцөлийг бүрдүүлж агуулах зоорийг нэмэгдүүлнэ.

2.4.2.3. Иргэд, аж ахуйн нэгжид атаршсан талбайг малын тэжээлийн зориулалтаар олгох, шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах болон үйл ажиллагааг явуулахад нь хөнгөлөлттэй зээлээр дэмжих, төсөл хөтөлбөрт хамруулан малын тэжээлийн ургамлын тариалалтыг нэмэгдүүлнэ.

Зорилт 3. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулж, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

2.4.3.1. Малын гаралтай бүтээгдэхүүн, түүхий эд боловсруулж байгаа үйлдвэрүүдийг дэмжиж, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.

2.4.3.2. Мах, сүү, гурил, гурилан бүтээгдэхүүн зэрэг хүнсний зарим нэр төрлийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангах, хүнсний шимт, тэжээллэг чанарыг нэмэгдүүлж, зарим хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулна.

2.4.3.3. Хөдөө аж ахуйгаас бэлтгэн нийлүүлэх арьс шир, түүхий эд, бүтээгдэхүүнийг төвлөрүүлэх, анхан шатны боловсруулалт хийх, стандартын дагуу бэлтгэн зах зээлд нийлүүлэх сүлжээг бий болгоно.

2.4.3.4. Хөдөө аж ахуйн түүхий эд бүтээгдэхүүний нөөцөд тулгуурлан үйлдвэрлэлийн болон борлуулалтын тогтолцоог кластер хэлбэрээр хөгжүүлнэ.

2.5. Газрын харилцаа, барилга хот байгуулалт, дэд бүтэц

Зорилт 1. Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөлтийн дагуу дэд бүтцийг хөгжүүлэх замаар орон нутагтаа тав тухтай ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

2.5.1.1. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

2.5.1.2. Арвайхээр суманд 30МВт хүчин чадалтай дулааны станцыг ашиглалтад оруулан, төрийн байгууллага, аж ахуйн нэгж, нийтийн орон сууц, айл өрхүүдийг дулааны төвлөрсөн сүлжээнд холбоно.

2.5.1.3. Аймгийн төвийн болон зарим сумдын хуучин орон сууцнуудыг дахин төлөвлөж, барилгын гадна фасад, дээврийг шинэчлэн засварлаж, орчны тохижилтыг хийж, хэрэглээний халуун усаар бүрэн хангана.

2.5.1.4. “Түрээсийн орон сууц”, “150 мянган айл-орон сууц” үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, иргэдийг чанар, стандартын шаардлага хангасан орон сууцаар хангаж, ипотекийн зээлд хамруулна.

2.5.1.5. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан гэр хорооллын дахин төлөвлөлтийг хэрэгжүүлж, инженерийн шугам сүлжээнд холбогдсон амины орон сууцны тоог нэмэгдүүлнэ.

2.5.1.6. Сумдын төвд хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээг бий болгон аж ахуйн нэгж, гэр хорооллын айл өрхүүдийг холбон, орон сууцжуулах нөхцөлийг бүрдүүлж, авто болон явган хүний зам, гэрэлтүүлэг, ногоон байгууламж, үерээс хамгаалах далан сувгийг, төлөвлөлтийн дагуу хийнэ.

2.5.1.7. Шинээр барих болон засварлах шаардлагатай орон нутгийн чанартай авто зам гүүрүүдэд ажлын зураг, төсвийг хийлгэж барих, засварлах ажлыг гүйцэтгэнэ.

2.5.1.8. Хархорин хотод зорчигч үйлчилгээний цогцолбор бүхий олон улсын нисэх буудал байгуулна.

2.5.1.9. Газар зохион байгуулалтын төлөвлөлт, газрын кадастр, үнэлгээ, газрын мониторинг, биржийн байнгын ажиллагаатай системийг хөтөлж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.

2.5.1.10. Хаягжилтын нэгдсэн системийг хөтлөн явуулна.

ГУРАВ. ЗАСАГЛАЛ

Зорилго: Нутгийн захиргааны байгууллагын бүх түвшинд засаглалын хариуцлага сайжирсан, хүний эрхийг хангасан, иргэн бүрт эрх тэгш, шударга үйлчилдэг, итгэл хүлээсэн төрийн албыг бэхжүүлнэ.

3.1. Ёс зүй, хариуцлагатай төрийн алба

Зорилт 1. Төрийн захиргааны байгууллагуудын чиг үүргийн хуваарилалтыг оновчтой зохицуулалтаар хангах замаар чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй, хариуцлагатай, тогтвортой төрийн албыг төлөвшүүлнэ.

3.1.1.1. Төрийн захиргааны байгууллагуудад чиг үүргийн шинжилгээ хийж, давхардал, хийдлийг арилган, ухаалаг засаглалыг дэмжсэн оновчтой бүтэц, зохион байгуулалтыг бий болгоно.

3.1.1.2. Төрийн албан хаагчийг тогтвортой ажиллах баталгааг хангаж, чадахуйн зарчмын хүрээнд шатлан дэвшүүлж ажиллуулах чиглэл баримтална.

3.1.1.3. Төрийн албанд ёс зүй, сахилга хариуцлагын мэдээллийн санг хөтлөн, түүнд дүн шинжилгээ хийж, ёс зүй, сахилга, хариуцлагыг бүрдүүлнэ.

3.1.1.4. Төрийн албаны сонгон шалгаруулалт, хүний нөөцийн томилгоо, сахилга хариуцлага, ёс зүйтэй холбоотой шийдвэрийг бүх байгууллагад ил тод болгож, хүний нөөцийн аудит хийнэ.

3.1.1.5. Төрийн албан хаагчийн сургалт хөгжил, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.2. Цахим засаглал, хамтын ажиллагаа

Зорилт 1. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг цахимжуулж, төрийн үйлчилгээг хялбаршуулан, зардал хэмнэх тогтолцоонд шилжүүлж, төрийн албан хаагчийн ажиллах орчинг сайжруулна.

3.2.1.1. Төрийн байгууллага хооронд болон тэдгээрээс иргэний нийгэм, бизнесийн байгууллага, иргэдтэй харилцах мэдээллийн солилцоо, ил тод байдлыг нэмэгдүүлнэ.

3.2.1.2. Төрийн байгууллагуудын интернетийн хурд, хүчин чадлыг нэмэгдүүлж, байгууллага дунд ашиглагдах мэдээллийн нэгдсэн сангийн дэд бүтцийг хөгжүүлнэ.

3.2.1.3. Төрийн байгууллагуудын барилгын ашиглалтын байдалд үнэлгээг хийж, үйл ажиллагааг төрөлжүүлэн, ашиглалтын менежментийг сайжруулна.

3.2.1.4. Сумдын Засаг даргын Тамгын газар, багийн төвийн барилгыг шинээр барих, засварлах, албаны автомашиныг шинэчлэх, багийн Засаг дарга нарыг

унаагаар хангах, төрийн байгууллагуудын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.3.Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

Зорилт 1. Аймгийн уламжлалт гадаад харилцааг өргөжүүлэн, эдийн засгийн тэргүүлэх салбарын харилцааг бэхжүүлнэ.

3.3.1.1. Уламжлалт хамтын ажиллагаатай гадаад орнуудын хот, мужуудтай хийх соёл, эдийн засгийн харилцааг өргөжүүлнэ.

3.3.1.2. Гуравдагч хөрш орнуудын хот, мужуудтай шинээр гадаад харилцаа, хамтын ажиллагааг тогтоож хөгжүүлнэ.

3.3.1.3. Эдийн засаг, нийгмийн тэргүүлэх салбаруудад мэргэшсэн хүний нөөцийг сургах, дадлагажуулах, харилцан туршлага солилцох үйл ажиллагааг гадаад хамтын ажиллагаатай хот, мужуудтай хамтран хэрэгжүүлнэ.

3.3.1.4. Олон улсад өрсөлдөхүйц инноваци, шинэ технологи, мэдлэг шингэсэн үйлдвэрлэл, үйлчилгээний бизнес төлөвлөгөө, санал санаачилгыг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад танилцуулж, хөрөнгө оруулалт татахад дэмжлэг үзүүлнэ.

3.4.Эрх зүйн боловсролтой иргэн, хүний эрхийг дээдэлсэн нийгэм, авлигагүй засаглал.

Зорилт 1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хүний эрхийг хангах, хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг оновчтой арга, хэлбэрээр зохион байгуулна.

3.4.1.1. Цахим технологид суурилсан арга хэлбэрээр хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааг зохион байгуулж, “Бүх нийтийн эрх зүйн боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.4.1.2. Сум бүрт эрх зүйн танхим, булан байгуулан, сайн дурын эрх зүйн хөтөчийг ажиллуулж, тэднээр иргэдэд хууль зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээллээр хангах, хууль тогтоомжийн лавлагаа өгөх үйлчилгээг нэвтрүүлнэ.

3.4.1.3. Хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг нэмэгдүүлж, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн арга хэмжээ, хяналт, шалгалтыг олон нийтийн оролцоонд тулгуурлан явуулж, үр дүнг нийтэд мэдээлнэ.

3.4.1.4. Аймагт хэрэглэгчийн эрхийг хамгаалах, шударга бус өрсөлдөөнтэй тэмцэх үүрэг бүхий ажилтныг ажиллуулж, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэгтэй төрийн бус байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлэн, иргэдийн гомдол, мэдээллийг шалгаж, буруутай этгээдэд хариуцлага тооцож ажиллана.

Зорилт 2. Олон нийтийг соён гэгээрүүлэх замаар авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэн, авлигатай тэмцэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.4.2.1. Олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, шударга ёсны үзэл санааг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг олон нийтийн оролцоонд тулгуурлан үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.4.2.2. Төрийн байгууллагуудад авлигаас урьдчилан сэргийлэх дотоод хяналтын нэгж ажиллуулан, төрийн албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлнэ.

3.5.Амар тайван, аюулгүй нийгэм.

Зорилт 1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг хамгаалах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлж, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг сайжруулна.

3.5.1.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг хамгаалах ажилд хөршийн холбоо, гудамжны ахлагчийг ажиллуулж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэн, теле-камерын хяналтын системийг хөгжүүлнэ.

3.5.1.2. Гэмт хэргийн гол шалтгаан болсон архидан согтуурах, зам тээврийн осол, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүдийг бууруулах, таслан зогсоох арга хэмжээг эрчимжүүлнэ.

3.5.1.3. Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх ажилд төрийн зарим байгууллагуудыг татан оролцуулж, цахим тоног төхөөрөмж ашиглан гэмт хэргийн гаралтыг эрс бууруулна.

Зорилт 2. Хууль сахиулах болон зарим хяналтын байгууллагууд, тэдгээрийн алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

3.5.2.1. Аймгийн “Төрийн Архив”-ыг зориулалтын байртай болгож, баримтын хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулна.

3.5.2.2. Хууль сахиулах болон хяналтын зарим байгууллагуудын барилгыг шинээр барьж, шаардлагатай техник хэрэгслээр үе шаттай хангаж, алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

3.6.Батлан хамгаалах, гамшгаас хамгаалах

Зорилт 1. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлэн, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилж, хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлнэ.

3.6.1.1. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангаж, сургалт явуулах орчин нөхцөлийг сайжруулна.

3.6.1.2. Аймгийн дайчилгааны төлөвлөгөө болон дайчилгааны даалгаврыг шинэчлэн боловсруулж, бэлэн байдлыг хангана.

3.6.1.3.Цэрэг-эх оронч хүмүүжил олгох орчин нөхцөлийг бүрдүүлэн, хүүхэд, залуучуудад эх оронч хүмүүжил төлөвшүүлэх олон талт арга хэмжээг хэрэгжүүлж, хугацаат цэргийн алба хаагч иргэдийн тоог нэмэгдүүлнэ.

Зорилт 2. Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлнэ.

3.6.2.1. Аймагт гамшгаас хамгаалах “Команд Штаб”-ын дадлага сургуулийг зохион байгуулна.

3.6.2.2. Сумдад гамшгийн эрсдэлийг бууруулах үнэлгээг аюулын төрлөөр нь эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлнэ.

3.6.2.3. Улсын чанартай авто зам дагуу болон хүн амын төвлөрөл ихтэй суманд эрэн хайх, аврах бүлэг, алслагдсан сумдад улсын нөөцийн цэг байгуулна.

Зорилт 3. Орон нутгийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хамгаалах үйл ажиллагаанд орчин үеийн дэвшилтэт арга технологи, техник, тоног төхөөрөмжийг нэвтрүүлнэ.

3.6.3.1. Гамшгийн аюулын зарлан мэдээлэл дамжуулах, “Радио холбооны тоон технологийн нэгдсэн систем” төслийг хэрэгжүүлэх, орон нутагт бааз станц, дуут цамхаг б айгуулж, сансрын холбоогоор хангана.

3.6.3.2. Цаг агаарын аюулт үзэгдэл, гамшгийн үеийн мэдээллийн судалгаа, шинжилгээний системийг бий болгон учирсан хохирол, сэргээн босгох хэрэгцээг тооцох арга, технологийг нэвтрүүлнэ.

ДӨРӨВ. НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Зорилго: Хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлогыг хэрэгжүүлэн хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

4.1. Усны нөөц

Зорилт 1. Усны нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх замаар экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.

4.1.1.1. Гадаргын ус хуримтлуулах хөв, цөөрөм, усан сан байгуулах, байгаль орчны доройтлыг бууруулах төсөл арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.1.1.2. Төв суурин газрын хүн амын ундны ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул, судалгааг хийлгэж, шаардлага хангасан, баталгаат усны эх үүсвэрийн нөөцийг тогтооно.

4.1.1.3. Орон нутгийн чанартай, бүрэн судлагдаагүй рашааны орд газруудад нөөц, чанар найрлагыг тодорхойлох судалгаа хийлгэнэ.

4.1.1.4. Томоохон голуудын урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад, тусгай хамгаалалтад байх газрын тоо, хэмжээг нэмэгдүүлнэ.

4.1.1.5. Ус, рашааны зохистой хэрэглээг төлөвшүүлж, төв суурин газрын ундны усны чанар аюулгүй байдлыг хангуулан, рашааны нөөц ашиглалтын талаарх дүгнэлтийг бодитой гаргах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

4.1.1.6. Орхон- Онги эко төслийг салбарын яамтай хамтран хэрэгжүүлнэ.

4.2. Байгалийн нөөц ашиглалт, нөхөн сэргээлт

Зорилт 1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр шинжлэх ухааны үндэслэлтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэн, байгалийн нөөцийг зохистой ашиглана.

4.2.1.1. Байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, дэд бүтцийн хөгжилтэй уялдуулан, байгаль орчны бохирдол доройтлоос сэргийлж, агаар орчны бохирдлыг бууруулна.

4.2.1.2. Уул уурхайн ашиглалтын улмаас эвдэрсэн талбайн нөхөн сэргээлтийг нэмэгдүүлж, орон нутгийн иргэдийн амьдрах орчин, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулна.

4.2.1.3. Нэн ховор, ховор амьтан, ургамлын тархац нөөцийн судалгааг өргөжүүлж, хамгаалалтын менежментийг сайжруулна.

4.2.1.4. Цөлжилтийг бууруулах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

4.2.1.5. Байгаль орчны хууль, тогтоомж, ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн боловсролыг олон нийтэд сурталчлан таниулж, стандарт, хэм хэмжээг мөрдүүлэн, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

4.3. Ойн нөөц

Зорилт 1. Ойн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, ойн хомсдол, доройтлыг бууруулах, ойг нөхөн сэргээх, ойжуулах замаар ойг тогтвортой ашиглахад чиглэсэн менежментийг хэрэгжүүлнэ.

4.3.1.1. Ойгоос бэлтгэх модны хэмжээг эрэлт нийлүүлэлтэд тулгуурлан оновчтой тогтоож, ойн арчилгаа, цэвэрлэгээний журмаар бэлтгэсэн модоор хэрэгцээг хангана.

4.3.1.2. Ойжуулах, ойн тэлэн ургалтыг дэмжих, нөхөн сэргээх, ой хамгааллын арга хэмжээ авах замаар ойн хомсдолоос сэргийлэн, ойгоор бүрхэгдсэн талбайн одоогийн байгаа түвшинг тогтвортой хадгална.

4.3.1.3. Хот орчмын ойжуулалтыг өргөтгөх замаар төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж, өмнөх жилүүдэд байгуулагдсан цэцэрлэгжүүлсэн талбайн арчилгаа, усалгаа, иж бүрдэл, өнгө төрхийг сайжруулна.

4.4. Аялал жуулчлал

Зорилт 1. Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

4.4.1.1. Аймгийн аялал жуулчлалын бүс нутгийн онцлогт тулгуурлан аялал жуулчлалын цогц арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж, аймгийн аялал жуулчлалын цахим мэдээллийн сан үүсгэн ажиллуулна.

4.4.1.2. Төвхөн хийдийн угтах орчныг сайжруулах, байгальд ээлтэй аялал жуулчлалыг дэмжих бодлого хэрэгжүүлж, Монгол Улсын төв цэгийн “Гал голомт цогцолбор” төсөл хэрэгжүүлж эхэлнэ.

4.4.1.3. Хархорин, Эрдэнэзуу музейг холбосон аялал жуулчлалын гудамж байгуулна.

4.4.1.4. “Хархорин XIII зуун” төсөл хэрэгжүүлж, эзэнт гүрний нийслэл Хархорум хотын туурийг ил музей болгоно.

4.4.1.5. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр Өндөр гэгээн Г.Занбазарын үйл хэргийг мөнхжүүлэх цогцолбор төвийг байгуулж эхэлнэ.

4.4.1.6. Зарим иргэдийг хөтөч, угтан үйлчлэгчийн зэрэг сургалтад хамруулж, нутгийн онцлогтой аялал жуулчлалыг хөгжүүлэн, бүтээгдэхүүн, үйлчилгээний, чанар, стандартыг сайжруулан жуулчдын тоог суурь түвшингээс 50 хувиар нэмэгдүүлнэ.

4.4.1.7. Монголын нүүдлийн соёлын онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэж, аялал жуулчлалын эргэлтэд оруулан, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

4.4.1.8. Аялал жуулчлалын гол чиглэл дагуу дэд бүтцийг хөгжүүлж, отоглох цэг, авто зам дагуу үйлчилгээний цогцолборыг байгуулна.

4.4.1.9. Тусгай хамгаалалттай газар нутгийн нөөц, даацад тулгуурласан эко аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

4.4.1.10. Аялал жуулчлалыг дараах маршрутаар хөгжүүлнэ. Үүнд:

- **Орхоны хөндийн аялал жуулчлалын маршрут:** Элсэн тасархай, Их, бага Монгол уул - Ширээт цагаан нуур - Монгол орны төв цэг, Хархорин-Эрдэнэзуу - Шанхын хийд – Хархорум музей - Хужирт сумын халуун рашаан, Үүртийн тохой - Төвхөн хийд, Улаан цутгалан - Бат-Өлзий сум
- **Тусгай сонирхлын аяллын маршрут:** Найман нуур, Орхоны хүрхрээгийн мөсний авиралт, Хужирт, Бат-Өлзий, Тарагт, Нарийнтээл, Зүүнбаян-Улаан сумдын халуун рашаан,
- **Говийн болон баруун бүсийн сумдын аяллын маршрут:** Арвайхээр, Мазар хотын туурь - Өөш шахлага - Арц богдын нуруу - Зүүн богд уул – Хүрэн хадны рашаан - Элсний эмчилгээ -Таацын цагаан нуур - Өшгөгийн их залаа - Өнц шилүүстэй - Шаргын тасархай, Шаамын рашаан - Хубилай хааны цэргийн хотын туурь.
- **Өндөр гэгээн Занабазарын түүхэн замналаар аялах маршрут:** Элсэн тасархай – Их, бага Монгол уул - Ширээт цагаан нуур - Монгол орны төв цэг, Өвгөн суварга - Сэрүүн булаг-Сангийн далай – Арвайхээр сумын Өндөр гэгээн Г.Занабазарын цэцэрлэгт хүрээлэн.
- **Зүүнбаян-Улаан сумын аялал жуулчлалын маршрут:** Цагаан бургас болон Баянзүрх хайрханы энергийн төв.

4.4.1.11. Сум бүрт байгаль, түүх, соёл, мал аж ахуй, танин мэдэхүйн чиглэлээр орон нутгийн аялал жуулчлалын сүлжээ бий болгож, түүнд түшиглэсэн соёлын үйлдвэрлэл, брэнд бүтээгдэхүүн бий болгоно.

4.4.1.12. Аймгийн Аялал жуулчлалын дэд хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлж, ажиллана.

-oOo-